



БОДЛОГЫН ТОЙМ: УУЛ УУРХАЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ГЭРЭЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

2004 ий 4 аяагүд нэдүи 19

Оршил

Санхүү, Эдийн Засгийн Яам (СЭЗЯ)-наас тавьсан хүсэлт болон Монгол улсын Засгийн газар, АНУ-ын ОУХА-ийн ЭЗБШӨЧ төслийн хоорондын хэлэлцүүдлийг үндэслэн ЭЗБШӨЧ төсөл нь Монгол улсын Засгийн газарт дараах асуудлаар дэмжлэг туслалцаа үзүүлэхээр тохиролцов. Үүнд:

- Уул уурхайн салбарын тогтвортой байдлын гэрээг бодлогын хэрэгсэл болгон ашиглахын тулд гэрээний нөхцүүдийг тохиролцох, удирдан зохицуулах талаар бусад орны тэргүүн туршлага, сургамжийг танилцуулах
- Санхүүгийн орлого, хөдөлмөр эрхлэлт, орлого, урсгал данс, хөрөнгийн тооцоо болон бүсийн үр нөлөө зэрэг асуудлаар тогтвортой байдлын янз бүрийн гэрээний хэлбэрийн үр нөлөөг тооцоолох эдийн засгийн болон санхүүгийн загварыг боловсруулах
- Монгол улсын уул уурхайн хамгийн чухал бүтээгдэхүүн, өрсөлдөгч улс орнууд болон тэдний татварын бодлого, мөн эдгээр бодлого нь Монголд хөрөнгө оруулалт хийх сонирхолтой гадаадын хөрөнгө оруулагчдын шийдвэрт хир нөлөөлж буй талаар урт хугацааны олон улсын зах зээлийн судалгаа гаргаж урьдчилан тооцоолох (хэрэгцээ, үнэ г.м.)
- Монгол улсын Засгийн газрын уул уурхайн салбарын бодлогын хувилбарын талаар мэдээлж байх альтернатив хэлбэрийг боловсруулах

Зөвлөмж

Үнэлгээний явцад гарсан гол зөвлөмжүүд:

1. Тогтвортой байдлын цогц гэрээг байгуулахдаа Засгийн газарт зөвлөгөө өгөх олон улсын хуулийн фирм, уул уурхайн мэргэжилтнүүдийг татан оролцуулах
2. Байгалийн баялаг ашиглах салбарт үйл ажиллагаа явуулж буй ялангуяа гадаадын хөрөнгө оруулалттай бизнесүүдэд өргөн цар хүрээтэй санхүүгийн урамшуулал үзүүлэх боломжийг харгалзан үзэх нь Засгийн газрыг богино ба урт хугацааны туршид орлогоос хувь хүртээ болгож хангаж, байгалийн баялаг ашиглах салбар нь ямар нэгэн аргаар татаас төлөх биш, харин эдийн засагт бүхэлд нь үр ашгаа өгөх болно. Өнөөгийн тогтолцоо нь аливаа уул уурхайн төслийн эхний 8-10 жилд ангийн татварыг хөнгөлж, дараачийн 3-5 жилд бууруулсан дүнгээр татвар ногдуулдаг. Уул уурхайн төслүүдийн эрх ангийн үүднээс авч үзвэл маш урт хугацааны турш (эсвэл дундаж уурхайн ашиглалтын хугацааны хагас)-ид байгалийн нөөц ашигласны төлбөрөөс улсын төсвийн орлогыг бүрдүүлнэ гэсэн үг. Татварын нийт дүн, хөрөнгө оруулалтын урамшууллын үүднээс байгалийн нөөц ашигласны татварын хэмжээг дахин эргэж харах нь зүйтэй.
3. НӨТ-ыг ногдуулахдаа ихээхэн хэмжээний хөрөнгийн урамшуулал бүхий төслүүдийн хувьд дахин нягтлах хэрэгтэй. Өнөөгийн тогтолцооны үед ийм төслүүдийн хувьд НӨТ-ыг тэглэх нь хайлуулах, баяжуулах зэрэг нэмүү өртөг бүхий хоёрдагч салбаруудыг хөтлөх чухал хөдөлгүүр хүчин зүйлсийг үгүй болгодог.
4. Санхүүгийн тохиромжтой хэрэгслийг (уул уурхайн дагалдах үйлчилгээ үзүүлэгч компаниудын хөгжлийг санхүүжүүлэх сан г. м.) бий болгох боломжийг судлах хэрэгтэй. Монгол улсад хөрөнгө оруулахыг сонирхогч уул уурхайн томоохон компаниудын үзэж буйгаар хэрэв нийм төрлийн санхүүгийн хэрэгсэл байсан бол дотоодын компаниудтай урт хугацааны гэрээ байгуулснаар эдгээр гэрээг зээл, лизингийн гэрээний хувьд барьцаа болгох ашиглаж болох ажээ.
5. Уул уурхай, байгалийн баялагийг ашиглах бусад салбараас улсын төсөвт орох орлого нь ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах бодлогын зорилтуудыг биелүүлэхэд чиглэгдэж, бага орлого бүхий иргэд, бизнесүүдэд ногдох татварын хэмжээг багасгахад чиглэгдэж байгаа эсэхийг нягтлах нь зүйтэй.
6. Ихээхэн хэмжээний хөрөнгийн урамшуулал бүхий төслүүдийн хувьд шаардлагатай үед дэд бүтцийн хөгжлийн гол асуудлуудыг шийдвэрлэх ёстой. Уул уурхайн томоохон төсөл нь авто ба төмөр зам, ус, цахилгаанаас гадна нийгмийн дэд бүтцийг зайлшгүй шаарддаг. Үүний зэрэгцээ уг төсөл нь хүрээлэн буй орчинд 30-40 жилийн хугацаанд бодитоор ч, бодит бус замаар ч нөлөөлдөг. Иймээс дэд бүтцийн хэрэгцээ шаардлага, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах арга хэмжээг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх (урамшууллын хүрээнд), санхүүжүүлэх зэрэг нь бодлогын түлхүүр асуудлууд юм. Хамгийн гол нь урамшуулал нь татварын орлогоос улсын төсөвт орох хэмжээг тодорхой биш хугацаагаар багасгах зэрэг дагалдах сөрөг нөлөө үзүүлэлгүйгээр, үр дүнтэй гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чиглэгдэх ёстой.
7. Засгийн газар нь урт хугацааны туршид үр нөлөө үзүүлэхүйц томоохон хэмжээний хөрөнгийн урамшуулал бүхий төслүүдийн хувьд мөрдлөг журам, шийдвэр гаргах тогтолцоог өөрчлөх талаар бодолцох нь зүйтэй. Ингэх нь дэд бүтэц, усны эх үүсвэр, байгаль орчин, ашигт малтмалын ашиглалт, эрчим хүч, хөрөнгө оруулалт, улсын төсвийн орлого, худалдааны бодлогоудыг цогцоор нь шийдвэрлэх боломжоор хангана. Одоо мөрдөж буй хуулийн дагуу тогтвортой байдлын гэрээг СЭЗЯ баталдаг. Харин сайд нарын бүрэлдэхүүнтэй зөвлөл юмуу Засгийн газар гэрээг баталдаг болох нь хөрөнгө оруулагчдад тохиолдож болзошгүй санхүүгийн эрсдийг багасгах, холбогдох яамд хоорондын мэргэжлийн зохицуулалт, Засгийн газраас санал болгосон тогтвортой байдлын гэрээнд шаардлагатай эдийн засаг, санхүү, хууль зүйн дүн шинжилгээг сайжруулах ач холбогдолтой юм.
8. Хэдийгээр Монгол улсын уул уурхайн салбарын хууль эрх зүйн тогтолцоог бусад орнуудынхтай жишвэл харьцангуй сайн ч тодруулах шаардлагатай асуудал, тусгай зөвшөөрлийн нөхцөл, тогтвортой байдлын гэрээнд хамрагдах төслийн наад захын шалгуур үзүүлэлт, хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн хэмжээг дахин хянах, татвар-санхүүгийн алдагдлыг дараагийн жилд шилжүүлэх хугацааг 5 хүртэл жил болгон сунгах, мөн бусад асуудлуудын талаархи зөвлөмжийг энэхүү үнэлгээний ажлын эцэст гаргалаа.

Мэдээллийн эх сурвалж

"Монгол улсын уул уурхайн салбарын өрсөлдөх чадвар ба тогтвортой байдлын гэрээг ашиглах нь" ЭЗБШӨЧ-ын тайланг үзнэ үү. ЭЗБШӨЧ, Улаанбаатар, Монгол Улс, 2004 оны 4 дүгээр сар